# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр Дугаар 314 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4,3 дахь заалт, 2019 оны 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэсант-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 51,573,483.00 (тавин нэгэн сая таван зуун далан гурван мянга дөрвөн зуун наян гурван) төгрөгийн балансын үнэ бүхий автомашин, механизмыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. "Эрдэнэсант-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Золжаргалд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлын хэсэг томилж, холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2019 оны 3 дугаар улиралд багтаан тайлангийн маягтаар ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.АРИУНБОЛД

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТ ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ТҮВШИНЗАЯА

0000561

C:\2019.07.22 16г huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохиц...
газрын 2019 оны 07 дугаар сар...
өдрийн 314 дугаар тогтоолын ...

## ...НЭСАНТ-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгсэл

| ...машины марк, улсын ...зориулалт, хөдөлгүүр, ... арлын дугаар | Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ /төгрөг/ | Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/ | Үлдэх өртөг /төгрөг/ | Сэргээн босголтын зардал /төгрөг/ | Ху... дө... /т... |
|---|---|---|---|---|---|---|---|
| ...маркийн, авто индүү, | 1990/0501 | | 12,114,375.00 | 12,114,375.00 | 0.00 | 158,500.00 | 500... |
| ...0 маркийн, 40-03 ТӨА ...н дугаартай, тусгай ...тын автомашин, арлын дугаар-1441482 | 1997/0101 | | 25,000,000.00 | 25,000,000.00 | 0.00 | 201,000.00 | 800... |
| ...аркийн, 31-16 ТӨВ улсын ...ай, ачааны автомашин, ... арлын удгаар- ...N1CJUP22Z008354 | 6/1/2012 | 306000 | 14,459,108.00 | 14,459,108.00 | 0.00 | 827,000.00 | 1,50... |
| | | | **51,573,483.00** | **51,573,483.00** | **0.00** | **1,186,500.00** | **2,80...** |
| **...Т ХӨРӨНГИЙН ДҮН** | | | **51,573,483.00 (тавин нэгэн сая таван зуун далан гурван мянга дөрвөн зуун наян гурван)** | **51,573,483.00 (тавин нэгэн сая таван зуун далан гурван мянга дөрвөн зуун наян гурван)** | | **1,186,500.00 (нэг сая нэг зуун наян зургаан мянга таван зуун)** | **2,80... (хо... най... м...** |